


Эрчим хүчний зохицуулах хорооны
2020 оны 09 дүгээр сарын
2-ны өдрийн /1707/ албан бичгийн хавсралт



ДУЛААНЫ ТООЛУУРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

No.	Техникийн тодорхойлолт	Техникийн үзүүлэлт
1	Техникийн ерөнхий шаардлага хангасан байх	EN 1434:2007, prEN 1434:2009 болон OIML R75:2002
2	Тоолуурын суурилуулалтын шаардлага	"MNS 6241:2011 Дулааны тоолуур. Суурилуулалт, ашиглалтад оруулах, ажиллагааг хянах, техникийн үйлчилгээний ерөнхий шаардлага" хангах
3	Тоолуурын баталгаат хугацаа	5 жилээс багагүй байх
4	Тооцоолуур зөвшөөрөгдөх алдаа	$EC \pm (0.15 + 2/\Delta\theta) \%$
5	Температурын датчикийн зөвшөөрөгдөх алдаа	$ET \pm (0.4 + 4/\Delta\theta) \%$
6	Механик орчны ангилал	M1 ангилал
7	Цахилгаан соронзон орчны ангилал	E1 болон E2 ангилал
8	Хамгаалалтын ангилал	IP54
9	Температурын зөрүүг хэмжих	$\Delta\theta: 3K \dots\dots\dots 170K$ хүртэл
10	Тэжээлийн хүчдэл	3.6 ± 0.1 В тогтмол
11	Даралтын дээд хязгаар	2.5 МПа
12	Температурын хэмжих хязгаар	$3^{\circ}C - 150^{\circ}C$
13	Тоолуурын ажиллах орчны температур	$5^{\circ}C - 55^{\circ}C$

Зарцуулалтын датчик:

- Зарцуулалтын датчик нь хэт авианы
- Фланцан холболттой

Тооцоолуур:

Дулааны тоолуурын тооцоолуур нь ажиллахад маш хялбар бөгөөд тооцоолуур дээрээс дараах мэдээллүүдийг харж болно.

- Нийт хэрэглэсэн дулааны хэмжээ МВт, ГКал, ГДж нэгжүүдээр гарна.

- Нийт усны эзлэхүүн
- Тоолуур ажилласан хугацаа
- Өгөх усны температур
- Буцах усны температур
- Өгөх буцах усны температурын зөрүү
- Сар болон жилийн дундаж температур
- Тухайн үеийн дулааны энергийн зөрүү
- Хамгийн их ба хамгийн бага дулааны энергийн хэмжээ
- Тухайн үеийн усны зарцуулалт
- Тухайн үеийн чадал, сар жилийн дундаж чадал
- Нийт хуримтлагдсан энергийн хэмжээ
- Мэдээллийн код

Тооцоолуур дээрх мэдээллийг цагаар болон, өдөр, сар, жилээр хадгалах, мэдээллийг хадгалах хугацаа 15 жилээс багагүй байна. Тоолуур дээр гарах доголдлыг мэдээлэх, мөн санах ойн багтаамж нь алдааны кодыг хадгалдаг байна.

Температурын датчик:

- Зэвэрдэггүй гангаар хийсэн гильзтэй датчик
- Утас нь стандартын шаардлага хангасан урттай байх.

Батарей:

- Литиум баттерейтай, ажиллах хугацаа 5-аас дээш жил байх.

Нэмэлт:

- Тоолуурын заалтыг зайнаас авах зориулалттай wireless модуль суурилуулах боломжтой байх.

Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилтад тэнцэж, Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн, дулааны тоолуурын лабораториор шалгагдсан, баталгаажуулалтын гэрчилгээ бүхий дулааны тоолуур байх.

“Хэмжих хэрэгсэл суурилуулах, засварлах ажил үйлчилгээ эрхлэх” эрх бүхий байгууллагаар тоолуурыг суурилуулна.

Бусад:

- Тоолуурын техникийн үзүүлэлтүүд нь зөрүүтэй тохиолдолд холбогдох стандартыг мөрдлөг болгон авч үзнэ.